

**“БАТЛАВ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Ү.ТӨМӨРХУЯГ**

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 21

**ХАБЭА-Н МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭНД ЭРСДЭЛИЙГ  
УДИРДАХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЧИЛГЭЭ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалт/  
дугаар:

гэрээний

**Хөдөлмөрийн нөхцлийн болон хөдөлмөрийн эрүүл мэндийн  
эрсдэлийн үнэлгээ хийлгэх**

**ДЦС4/2020-335**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.   |
|   | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) ТООЗ-д заасан шаардлагууд  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 5.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 6.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.   |
|   | 6.2. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.  |
| <b>7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 7.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн <i>нэг</i> жилийн санхүүгийн тайлан Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн тайлан 2019 аудитлагдсан,</li> <li>• Компаний гэрчилгээний хуулбар,</li> <li>• Туршлагын мэдээлэл. /Нотлох баримтын хамт/</li> <li>• Тусгай зөвшөөрлийн хуулбар</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө мэргэжилтэн Ж.АЙДОС Утас: 70181309</i></p> <p>Огноо: <i>2020 оны 5 дугаар сарын 29 ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээх хаяг, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө</i></p> <p>Огноо: <i>2020 оны 5 -р сарын 29 -ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>дугаартай ДЦС4/2020-335 “Хөдөлмөрийн нөхцлийн болон хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх</i></p>

Түлш дамжуулах цехэд хөдөлмөрийн нөхцлийн болон эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлын даалгавар

А. Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.

1. Ажлын байран дахь тоосыг хувь хүний сорьцоор хэмжиж тодорхойлох. Ерөнхий тоосролтыг ажлын байранд хэмжих.
2. Ажлын байран дахь орчны эрүүл ахуйн физик үзүүлэлтүүд болох агаарын хэм, харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөний хурд, гэрэлтүүлэг, шуугиан (хувь хүний сорьц цуглуулна) хэмжинэ.
3. Хэсгийн болон ерөнхий доргиог хэмжинэ.
4. Тогтмол соронзон орон, цахилгаан статик орон, үйлдвэрлэлийн давтамжтай соронзон
5. Биеийн хүчний ачаалал. (Ажлын ээлжийн туршид биеийн хүчний динамик ачаалал, гараар өргөж зөөх ачааны хэмжээ, ээлжинд гүйцэтгэх нэг маягийн хөдөлгөөний тоо, ажиллах байц байршил)
6. Мэдрэл сэтгэхүйн ачаалал (Мэдрэхүйн ачаалал, сэтгэл хөдлөлийн ачаалал, нэг ажилбарын давтагдах байдал, ажлын горим)
7. Хөдөлмөрийн эрүүл мэндийн удирдлага менежмент, хэрэгжилтийн үнэлгээ хийх

Б. Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг ижил өртөлттэй бүлэг бүрт хийх

В. Ажлын байруудыг MNS 5080:2001 стандартын дагуу ангилах.

Г. Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн зөвлөмж боловсруулах.

## Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх байгууллагад тавих шаардлага

1. ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн Хөдөлмөрийн эрүүл ахуйн лабораторитой байх эсвэл дээрх шаардлагыг хангасан лабораторид сорьцыг шинжилдэг байна.
2. Ажлын байран дахь сөрөг хүчин зүйлийг хувь хүний түвшинд ажлын ээлжийн турш /урт хугацааны турш/ хэмждэг байх
3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэй байх
4. Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 тоот тушаалаар батлагдсан “ Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх журам”, ХАБЭА-н үндэсний хорооны 2016 оны 5 сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “ Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж”, Хөдөлмөрийн нөхцлийн ангилал MNS 5080:2001 болон бусад стандартуудыг жишиг болгон үнэлгээ хийнэ.
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16-д заасан шаардлагыг хангасан байх.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 1. Ерөнхий зүйл** Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарь болон техникийн тодорхойлолтод заасны дагуу үйлчилгээг үзүүлэхдээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн арга техник болон практик зарчмын дагуу өөрийн үүргийг хэмнэлттэй, үр ашигтай, чармайлт гарган гүйцэтгэх ба сайн удирдлага, зохион байгуулалттайгаар ажиллаж аюулгүй арга хэлбэр, тохиромжит дэвшилтэт технологийг ашиглана. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний эсхүл үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа явуулахдаа захиалагчид ямагт шударга зөвлөгөө өгөх бөгөөд туслан гүйцэтгэгч эсхүл гуравдагч этгээдтэй харилцах аливаа асуудалд хандахдаа ямагт захиалагчийн хууль ёсны эрх сонирхлыг хамгаалж, дэмжиж ажиллана
- 2. Гүйцэтгэгч нь** Гүйцэтгэгчид төлөх үйлчилгээний нийт хөлс нь зөвхөн энэ

**аливаа урамшуулал, хөнгөлөлтөөс ашиг хүртэхгүй байх.**

гэрээ буюу үйлчилгээтэй холбогдож төлөгдөх үйлчилгээ үзүүлсэний төлбөр байх бөгөөд Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу, эсхүл гэрээний үүргээ биелүүлэхэд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаатай холбогдуулж өөрт ашигтайгаар урамшуулал, хөнгөлөлт, болон ижил төстэй төлбөрийг бусад этгээдээс авахыг үл зөвшөөрнө.

### **3. Зөрчилтэй үйл ажиллагаанд оролцохыг хориглох**

Гүйцэтгэгч нь эсхүл түүний туслан гүйцэтгэгч эсхүл тэдгээрийн ажилтан дараах үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохыг хориглоно. Үүнд:

- (a) Гэрээний хэрэгжилтийн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж буй үйл ажиллагаатай зөрчилдөх аливаа бизнесийн эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;
- (b) Гэрээний хэрэгжилтийн хугацаанд Гүйцэтгэгч нь эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн зүгээс төрийн албан хаагчийг гэрээний дагуу явуулах аливаа үйл ажиллагааг гүйцэтгэх үндсэн ажилтнаар хөлсөлж ажиллуулах;
- (c) Энэхүү гэрээ дууссанаас хойш гэрээний тусгай нөхцөлд заасан бусад үйл ажиллагаа явуулах.

### **4. Нууцлал**

Гүйцэтгэгч нь, түүний туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтан нь тухайн гэрээ, төсөл, үйлчилгээ болон Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой өмчлөлийн болон нууц мэдээллийг гэрээний хэрэгжилтийн явцад болон гэрээг хэрэгжүүлж дууссанаас хойш (2) жилийн хугацаанд захиалагчийн бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.



## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

### Гүйцэтгэгчийн боловсон хүчин

- 1 Боловсон хүчний тодорхойлолт** Гүйцэтгэгч нь голлох боловсон хүчний албан тушаал, санал болгож буй ажлын байрны тодорхойлолт, чадварын доод шаардлагууд болон үйлчилгээг гүйцэтгэхэд ажиллуулахаар тооцсон хугацаа зэрэг нь Хавсралт В-д тодорхой тусгагдсан. Хавсралт В-д нэр, албан тушаалаар нь жагсааж бичсэн голлох боловсон хүчин болон туслан гүйцэтгэгчдийг захиалагч үүгээр зөвшөөрч байна.
- 2 Боловсон хүчнийг солих/ халах**
- (а) Захиалагч зөвшөөрснөөс бусад тохиолдолд Голлох боловсон хүчин/ажилтанд өөрчлөлт хийгдэхгүй. Хэрэв Гүйцэтгэгчээс хамаарахгүй шалтгаанаар голлох боловсон хүчин/ажилтныг солих шаардлага гарвал Гүйцэтгэгч нь түүнтэй ур чадвараараа дүйцэхүйц эсхүл түүнээс илүү чадвартай боловсон хүчнийг оронд нь ажиллуулахаар санал болгоно.
  - (б) Хэрэв гүйцэтгэгчийн боловсон хүчин нь (i) эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон болох нь тогтоогдсон, (ii) гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн зэргийг захиалагч мэдсэн бол эдгээр үндэслэлээр тухайн ажилтныг захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц чадвар, туршлагатай өөр ажилтнаар солиулах хүсэлтийг гүйцэтгэгчид бичгээр гаргана.
  - (в) Боловсон хүчнийг халах эсхүл солих үйл явдалтай холбоотой гарах аливаа нэмэлт зардлыг гүйцэтгэгч захиалагчаас нэхэмжлэх эрхгүй.

### 2. Чанарын хяналт

- 3. Зөрчил гологдол илрүүлэх** Захиалагч гүйцэтгэгчийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Ийнхүү шалгах нь Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Захиалагч зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, уг үйлчилгээний далд хэсгийг нээх, аль нэг үйлчилгээний туршилт хийхийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Чанарын баталгаат хугацааг ГТН-д тодорхойлсны дагуу байна



- 4. Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээтэй холбоотой гарах аливаа маргааныг харилцан зөвшилцөж эв зүйгээр шийдвэрлэхийг хичээнэ. Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.
- 5.Нэмэлт өөрчлөлт** Энэ гэрээний цар хүрээ, үнэтэй холбоотой болон бусад нөхцөл болзолд оруулах өөрчлөлт нь зөвхөн талуудын бичгээр үйлдсэн тохиролцоонд үндэслэх ба гэрээний санхүүжилтийг хариуцаж буй засгийн газрын холбогдох байгууллагын зөвшөөрөл авсанаар уг тохиролцоо нь хүчин төгөлдөр болно.
- 6.Тодорхойлолт** Энэ гэрээний зорилгын хүрээнд аль нэг талын боломжит хяналтаас гадуур давагдашгүй хүчний шинжтэй байдал бий болж энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх эсхүл тодорхой нөхцөл байдлын улмаас боломжгүй гэж үзэж болохоор нөхцөл байдал үүссэнийг Форсе-Мажор гэж ойлгоно.
- 7.Алданги оногдуулах** Гүйцэтгэгчийн гэрээний хугацаанаас хоцруулсан ажил, үйлчилгээнд гүйцэтгээгүй үүргийг үнийн дүнгээс хоног тутамд 0,01%-ийн алданги ногдуулна
- 8 Төлбөр** Гүйцэтгэгчид Урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд төлбөрийн нэхэмжлэх холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч үнэлгээний тайланг хүлээн авсанаас хойш 90 хоногийн дотор төлбөрийг хийнэ.

Дөрөв. “Хөдөлмөрийн нөхцлийн болон хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх ”-ын үнийн саналын маягт

[огноо]

**“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.ТӨМӨРХУЯГ** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
2. Гүйцэтгэгч тодорхойлолтыг шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: